

91

ДОРНОГОВЬ АЙМАГ
“ЗАМЫН-ҮҮДИЙН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨРИЙН ӨМЧИТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 4/61

Замын-Үүд сум

Техникийн нөхцөл олгох комисс
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 290, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2016 оны 84 тоот тогтоол, “Замын-Үүдийн Дулааны станц” ТӨҮГ-ын дүрмийн 6.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ус, дулаан хангамж, ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд хэрэглэгчийг холбох техникийн нөхцөл олгох комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: "Замын-Үүдийн Дулааны станц" ТӨҮГ-ын Захирал
Нарийн бичгийн дарга: Ерөнхий инженер, Үйлдвэр техникийн хэлтсийн дарга
Гишүүд: Зуух, шугам сүлжээний горим тооцооны инженер
Ус хангамж, ариутгах татуургын албаны дарга
Зураг, төсвийн инженер
Засаг Даргын Тамгын газрын Газрын даамал
Хотын Захирагчийн ажлын албаны сумын ерөнхий архитекторч
Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

2. "Техникийн нөхцөл олгох журам"-ыг нэг дүгээр, дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох тодруулах хуудсыг хоёрдугаар, ус хангамж, ариутгах татуургын сүлжээнд хэрэглэгчийг холбох техникийн нөхцөл олгох тодруулах хуудсыг гуравдугаар, техникийн нөхцөл олгохтой холбоотой үнэ тарифыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2021 оны А/07 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Ус, дулаан хангамж, ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд хэрэглэгчийг холбох техникийн нөхцөл олгох журам болон бусад хууль, дүрмийг мөрдөж ажиллахыг комиссын нийт бүрэлдэхүүнд, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын мэргэжилтэн (З.Давааням)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



О.ТӨМӨРХУЯГ

44013 0101181

**ЗАМЫН-ҮҮД СУМЫН ТӨВЛӨРСӨН УС, ДУЛААН ХАНГАМЖ, АРИУТГАХ
ТАТУУРГЫН СҮЛЖЭЭНД ХЭРЭГЛЭГЧИЙГ ХОЛБОХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ
КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь Замын-Үүд сумын төвлөрсөн ус, дулаан хангамж, ариутгах татуургын сүлжээнд барилга байгууламжаа холбуулах иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, объект, тоног төхөөрөмжийг өргөтгөх, шинэчлэх, сүлжээнд холбох үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг хариуцлага, эрх хэмжээг тодорхойлоход оршино.

1.2 Техникийн нөхцөлийг техникийн нөхцөлийн комиссын бүрэлдэхүүн Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 290 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Дулаан дамжуулах, түгээх сүлжээний холболтын журам”, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2016 оны 84 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд хэрэглэгчийг холбох техникийн нөхцөл олгох журам” болон энэхүү журмын дагуу олгоно.

Хоёр. Комиссын эрх, үүрэг

2.1 Комисс нь техникийн нөхцөл олгоход зайлшгүй шаардлагатай мэдээ, судалгааг холбогдох байгууллага, хувь хүнээс гаргуулж авах эрхтэй.

2.2 Техникийн нөхцөлд тусгагдсан шаардлагыг зөрчсөн, хүчинтэй хугацаанд холболтын ажлыг хийж гүйцэтгээгүй, тухайн хэрэглэгчийн хэрэглээний горим болон инженерийн байгууламжид өөрчлөлт ороход хэрэглэгч нь хангагч байгууллагад албан ёсоор мэдэгдээгүй, анхны техникийн нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах, сунгуулах буюу, техникийн нөхцөл аваагүй бол техникийн нөхцөлийг хүчингүй болгох эрхтэй.

2.3 Хэрэглэгч нь техникийн нөхцөлийг дур мэдэн өөрчилсөн, техникийн нөхцөлд тусгасан шаардлагыг зөрчсөн, техникийн нөхцөлгүй болон дур мэдэн холболт хийсэн байгууллага, иргэнийг инженерийн хангамжаар хангахаас татгалзах шийдвэрийг техникийн нөхцөл олгох комиссын хурлаар хэлэлцэн шийдвэрлэх эрхтэй.

2.4 Техникийн нөхцөл олгохдоо “Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуулийн 11 дүгээр зүйл, Дулаан эрчим хүч хэрэглэх дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2-д заасны дагуу захиалагч буюу хэрэглэгчдэд зохих шаардлагын тавих үүрэгтэй.

2.5 Техникийн нөхцөл олгох үйл ажиллагаатай холбогдож гарсан өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд багтааж хянан шийдвэрлэх үүрэгтэй.

Гурав. Комиссын үйл ажиллагаа

3.1 Комиссын бүрэлдэхүүн 5-9 дүгээр саруудад сард хоёроос доошгүй удаа хуралдах бөгөөд ээлжит бус хурлыг комиссын дарга зарлан хуралдуулна. Шаардлагатай тохиолдолд хуралд холбогдох байгууллага, иргэн, аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулж болно.

3.2 Гишүүдийн дийлэнх нь ирснээр комиссын хурлыг явуулна. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралд оролцоогүй гишүүдийн саналыг татгалзаагүйд тооцно.

3.3 Комиссын нарийн бичгийн дарга хуралд орох материалыг хянаж ажлын 10 хоногийн дотор комиссын хурлаар хэлэлцүүлнэ.

3.4 Комиссын гишүүд тус бүр саналаа ил тод илэрхийлнэ. Комиссын гишүүдийн олонхын саналаар хурлын шийдвэрийг эцэслэн гаргана.

3.5 Комиссын нарийн бичгийн дарга техникийн нөхцөлийн хурлыг товыг комиссын бүрэлдэхүүнд 3 хоногийн өмнө мэдэгдэнэ.

3.6 Комиссын нарийн бичгийн дарга нь хурлын шийдвэр, нэмэлт нөхцлийн хэрэгжилтэнд хяналт тавьж, ажлын явцыг тайлагнана.

3.7 Комиссын хэлэлцсэн асуудлаар нарийн бичгийн дарга хурлын тэмдэглэл хөтөлж, комиссын дарга гарын үсэг зурж, баталгаажуулна. Хурлын тэмдэглэлийн 1 хувийг архивт үлдэх материалд хавсаргана.

3.8 Комиссын нарийн бичгийн дарга нь техникийн нөхцөл олгосон комиссын шийдвэр болон холболтын зураг схемийг цахим хэлбэрээр бүрдүүлж байгууллагын архивт хадгалах бөгөөд тухайн орон нутгийн Засаг даргын Тамгын газарт хүргэх ажлыг зохион байгуулна.

3.9 Комисс нь шинээр хэрэглэгч нэмж холбох боломж, дулаан дамжуулах, түгээх сүлжээнд хийгдэхээр хөрөнгийн эх үүсвэр нь батлагдсан өргөтгөл, шинэчлэлийн ажлуудын талаарх мэдээллийг газар зүйн байршлаар нь гаргаж улирал бүр нийтэд мэдээлнэ.

Дөрөв. Техникийн нөхцөл олголт

4.1 Хэрэглэгч хүсэлтээ хангагч байгууллага буюу "Замын-Үүдийн дулааны станц" Төрийн өмчит үйлдвэрийн газарт гаргана.

4.2 Хүсэлт нь дулаан, ус хангамж, ариутгах татуургын сүлжээнд холбохыг хүссэн албан хүсэлт, орон нутгийн Засаг даргын баталсан газар олголтын захирамж буюу /газар ашиглах, эзэмших, өмчлөх эрхийн гэрчилгээ/, кадастрын зураг, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэний үнэмлэхний хуулбар, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, байгууламжийн ус хангамж, ариутгах татуургын системийн хүчин чадал буюу хоногийн хэрэглээний усны хэмжээ, барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг, шаардлагатай дулааны ачааллын тооцоо (Гкал/цаг), хувийн өмчийн дулааны шугам сүлжээнээс холболт хийх тохиолдолд тухайн шугам, сүлжээний өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрөл зэргээс бүрдэнэ.

4.3 Техникийн нөхцөл нь комиссын хурлын шийдвэрийг үндэслэн комиссын дарга баталснаар хүчин төгөлдөр болно.

4.4 Техникийн нөхцөл нь олгогдсон өдрөөс хойш 2 жилийн хугацаанд хүчинтэй байна.

4.5 Техникийн нөхцөлийг хүрэлцээтэй хувиар үйлдэж холбогдох байгууллагад хүргүүлнэ.

Тав. Бусад зүйл

5.1 Хангагч болон орон нутгийн төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж нь гүйцэтгэлийн ажлын зураг төслийг барилгын норм, дүрэм болон стандартад заасан техникийн нөхцлийн дагуу шаардлага хангасан эсэхийг ажлын 5 хоногт багтаан хянаж, шалгана. Хангагч нь хэрэглэгчийн шугам сүлжээний батлагдсан ажлын болон далд ажлын гүйцэтгэлийн зураг, угсралтын холбогдох ажлын актыг цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах гэрээтэй хамт хавсаргаж, архивт хадгална.

5.2 Иргэн, хуулийн этгээд нь өөрийн хэрэглээний өгөгдлүүдээ зориуд болон санамсаргүй байдлаарбуруу тодорхойлон техникийн нөхцөл батлагдсанаас гарсан хохирлыг өөрөө хариуцна.

5.3 Техникийн тодруулгыг өгөхдөө шугам сүлжээний ачаалал, хэвийн ажиллагааг хангах зарчмыг баримтлах бөгөөд техникийн тодруулгаас үүдэн гарсан хариуцлагыг техникийн нөхцөл олгосон болон техникийн тодруулга өгсөн комисс хүлээнэ.

5.4 Техникийн нөхцөлтэй холбоотой гарсан маргааныг энэхүү журам болон Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох хууль, дүрэм, журмын дагуу шийдвэрлэнэ.

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭС



ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ
ТОДРУУЛАХ ХУУДАС

Дугаар №

20.. оны .. дугаар сарын .. өдөр

Замын-Үүд сум

1. Техникийн нөхцөл авахаар хүсэлт гаргаж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэний нэр хаяг, утас

2. Техникийн нөхцөл авах объектийн байршил, хаягийн тодорхойлолт

3. Техникийн нөхцөл авах болсон шалтгаан

5. Хэрэглэгчийн зэрэглэл, ажлын горим

6. Цаашид өргөтгөх бол эхлэх, дуусах хугацаа, хүчин чадал

(өргөтгөх бол хэзээ, ямар хүчин чадал нэмэгдэх кВт)

.....

7. Орон нутгийн засаг захиргааны газар олголтын тогтоолын дугаар, огноо

.....

8. Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа

ТОДРУУЛАХ ХУУДАС БИЧСЭН (.....)

УСАН ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН ТӨВЛӨРСӨН СИСТЕМД
ХЭРЭГЛЭГЧИЙГ ХОЛБОХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛИЙН
ТОДРУУЛАХ ХУУДАС

№

20.. оны .. сарын .. өдөр

1. Шинээр баригдах барилга, объектын нэр, хаяг:
2. Захиалагч байгууллагын хаяг ба түүний төлөөлөгчийн албан тушаал, харилцах утас:
.....
3. Зураг төсөл боловсруулах байгууллагын хаяг, утас:
4. Барилгын хэлбэр, давхрын тоо, өндөр /м/:
5. Объектыг барьж эхлэх, дуусах хугацаа: Зураг төсөл боловсруулах хугацаа:
6. Технологийн хэрэгцээний цэвэр усны хэмжээ м3/хоног:
7. Ахуйн хэрэгцээний цэвэр усны хэмжээ м3/хоног:
8. Технологийн хэрэгцээнээс гарах бохир усны хэмжээ м3/хоног:
9. Аж ахуйн хэрэгцээнээс гарах бохир усны хэмжээ м3/хоног:
10. Гал унтраахад зарцуулагдах усны хэмжээ л/сек:
11. Бохир усны найрлагад:
 - а/ умбаар бодис мг/л
 - б/ угаагч бодис мг/л
 - в/ нефть, нефтэн бүтээгдхүүн мг/л
 - г/ БПК*, ХПК* мг/л
 - д/ хүхэрт будаг мг/л
 - е/ хром болон бусад хорт бодис
12. Барилгын талбайн хэмжээ, м3:
13. Газар олголтын захирамж:
14. Дараачийн өргөтгөл эхлэх хугацаа, хүчин чадал:
15. Барилгын байршилтын схем дээр газар доорхи инженерийн шугам сүлжээг зурсан байна.

*БПК- хүчилтөрөгчийн биохимийн хэрэгцээ

*ХПК- хүчилтөрөгчийн химийн хэрэгцээ

ТОДРУУЛАХ ХУУДАС БИЧСЭН (.....)